

УРЬДЧИЛСАН УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

№01

Улаанбаатар хот

“Эрдэнэс тавантолгой” ХК-иас зарласан ЭТТХК/202301021 дугаартай “Нүүрс ачилт, буулгалтын талбай буюу гаалийн хяналтын бүсийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил” гүйцэтгэгчийг сонгох тендерийн ТШЗ 9.1-д заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 15 цагт zoom meeting ID 4102035897 хаягаар урьдчилсан уулзалтыг товлосны дагуу зохион байгуулсан. Урьдчилсан уулзалтаар тендерт оролцохыг сонирхогч 3 этгээд мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөллүүд 6 хүн нийт 11 хүн оролцлоо.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Тендерийн баримт бичгийг танилцуулах
2. Тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд тендерийн баримт бичигтэй холбогдуулан асуулт асуух
3. “ЭТТ” ХК-иас үнэлгээний хорооны гишүүд болон захиалагч нэгжээс асуултад хариулж мэдээлэл өгөх
4. Уулзалтын тэмдэглэлийн хөтөлж, цахим системд байршуулах.

СОНССОН НЬ:

Үнэлгээний хорооны гишүүн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе, “Эрдэнэс тавантолгой” ХК-иас зарласан ЭТТХК/202301021 дугаартай Нүүрс ачилт, буулгалтын талбай буюу гаалийн хяналтын бүсийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгох тендерийн ТШЗ 9.1-д заасны дагуу урьдчилсан уулзалтыг хийж байна.

Тендерийн баримт бичиг болон ажлын даалгавартай холбоотой асууж тодруулах зүйл байвал мэдээлэл өгч, асуултанд хариулахаар үнэлгээний хорооны гишүүд болон захиалга гаргасан нэгжийн ажилтнууд уулзалтанд оролцож байна.

Асуулт: Тендерт шалгараад 90 хоногт зургаа зурах юм байна, барилга угсралтын ажлыг 8 сар хийх юм байна. Энэ дээр геологи болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гэж хийгдэх үү? Энэ хугацаанд багтах уу? Магадлангаар орохоор тусдаа бас журам байдаг.

Хариулт: Тийн энэ хугацаанд зураг төсөв нь иж бүрдлээрээ хийгдэнэ. Магадлангаар ороход 14 хоног байдаг. Гэрээний нийт хугацаанд ажлаа бүрэн хүлээж авна, дулааны улирал эхэлж, газар хөндөх үед зураг бэлэн байх ёстой л гэсэн шаардлага тавьж байгаа.

Асуулт: Бас нэг тодруулах зүйл байна. Тендер зарласан өдрөөс хойш урьдчилсан төсөв тооцоо хийж үзсэн. 5 ширхэг автопүүтэй 6 тусгай зөвшөөрлийн хүрээнд зөөврийн сууцнууд эрчим хүч, харилцаа холбоо, зам гэсэн зүйлүүд байна. Эдгээр зүйлсүүд хэдэн оны төсвөөр танайх 11,207,563,000 төгрөг гэж тооцсон бэ? Манай компанийн тооцооллоор нилээд тулсан төсөв байна, цаашдаа төсөв нэмэгдэх боломжтой юу?

Хариулт: За тэрнийг бид хуулийн хүрээндээ авч үзнэ. Магадлашгүй ажлаа харна. Зураг төсөвт өөрчлөлт ороод ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд хуульд нийцүүлээд шийдэхэд асуудалгүй гэж үзэж байна.

Асуулт: Нүүрсний агуулах болоод зассан зам гэж байгаа энэ нь бетон зам биш гэж ойлгож байгаа зөв үү?

Хариулт: Бетон зам байхгүй гэж үзэж байна. Дэвссэн талбайг нягтаршуулаад гаалийн талбай болгох, гаалийн талбайд бетон зам байдаггүй. Захиалагч талаас ямар нэгэн нэмэлт шаардлага тавьсан уу үгүй юу гэдэг байна. Хучилтын байгууламж маань бол бетонон талбайтай. Бусад нь бол нягтруулсан талбай байгаа. Нягтыг бол норм дүрмийн дагуу шаардана.

Асуулт: За ойлголоо, өөр асуух зүйл байхгүй байна.

Асуулт: Үнийн тохируулга гэж байгуу юу? Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэж ойлгосон. Зураг төсөлөө өөрсдөө боловсруулж байгаа гэдэг утгаар, бид барилгын хөгжлийн төв юмуу төсвөө

магадлангаар оруулаад гэрээндээ үнийн тохируулга хийе гэж болох уу? Тэрнийг та бүхэн яаж харж байна вэ?

Хариулт: Тендерийн баримт бичигт үнийн тохируулга хийхгүй гэж заасан байгаа. Гэрээний тусгай нөхцөлийн 5.2-т үнийн тохируулга хийхгүй гэж оруулсан байгаа.

Асуулт: Тэхээр үнийн тохируулга хийхгүй л гэсэн үг юм байна, сая хуулийн хүрээнд болно гэхээр нь асууж байна.

Хариулт: Нэмэлт ажил хийгдвэл хуулийн хүрээнд нэмж болно. Тэрнээс яг байгаа ажлын хүрээнд үнийн тохируулга хийхгүй, төсөвтөө багтааж хийнэ.

Асуулт: Аан за ойлголоо. Энэ төсөв нь 2 жилийн өмнө ч юмуу тооцсон төсөв үү? 2023 онд шинээр тооцож үзсэн төсөв үү? Ихэнх ажил техник ашиглаж байгаа, түлшний үнэ өссөн бусад зүйлийг тооцсон уу?

Хариулт: Зураг төсвийн хувьд өмнө нь тусдаа явагдаж байгаад компанийн тодотгол төсвөөр түлхүүр гардуулах нөхцөлтэй болж батлагдсан учраас тооцооллыг энэ оныхоор хийсэн байх гэж үзэж байна.

Асуулт: Энэ автопүү монгол программтай байна гэсэн байна. Энэ нь уул уурхайд ашигладаг программтай дүйцэхүйц байх уу эсвэл танай программ байх ёстой юу?

Хариулт: Автопүү нийлүүлдэг компаниуд ижилхэн программ ашигладаг. Тусгай зөвшөөрөлтэй компаниар угсруулж, суурилуулж баталгаажуулалтаа хийлгэнэ.

Асуулт: Сервер нь танайх уу?

Хариулт: Тийн сервер манайх хангана. Өөр оролцогч нараас асуух асуулт байна уу?

Асуулт: 8 асуулт байна. Нэг бүрээр асуугаад хариултаа аваад явчихуу?

Хариулт: Болно.

Асуулт: Эхний асуулт ТББ-тэй холбоотой асуулт байна. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэж ойлгосон. ТШЗ 17.6-д ижил төстэй ажлыг 2020-2023 оны хооронд 5,6 тэрбумын ажил хийсэн байна. Ижил төстэй ажилд барилга угсралтын ажлыг тооцно гэсэн байна. Тэхээр зураг төсвийн компаниаар түншлэлээр орж байгаа учраас түншлэлийн гишүүн бүр 25 хувийг заавал хангах болчоод байгаа. Зураг төсвийн компани барилга угсралтын ажил хийсэн туршлага байдаггүй бусад ажлууд ч гэсэн. Үүнийг үнэлгээнд яаж харгалзаж үзэх вэ? Эсвэл зураг төсвийнхөө компанийг туслан гүйцэтгэгчээр авч орно гэсэн үг үү?

Хариулт: Туслан, түншлэлээр алингаар нь авахаа та хэд өөрсдөө шийднэ.

Асуулт: Тийн бид нар шийднэ. Гэхдээ ижил төстэй ажил дээрээ барилга угсралтын ажил байна гээд хязгаарласан учраас тодруулж байна.

Хариулт: Энэ асуултыг Үнэлгээний хороон дээрээ ярилцаад тодруулгаар хариу өгнө.

Асуулт: За мөн ТШЗ-ийн 5.9-д туслан 20 хувь, түншлэл 5 хувь гээд заасан мөртлөө ТШЗ 17.8-д туслан гүйцэтгэгчийн хувь хэмжээ 10 хувь гэсэн байсан. Энэ 2-ыг нийцүүлж өгөх хэрэгтэй байна.

Хариулт: За энэ заалтын хувьд ТШЗ 5.9-д зааснаар явна. ТШЗ-17.8-д жишиг баримт бичгээс хуулагдаж тавигдсан байна. Засаад тодруулгаар оруулаад явна.

Асуулт: За 3 дахь асуулт асууя. ТББ-т олон тусгай зөвшөөрөл байгаа. Зураг төсвийн компаниа туслан гүйцэтгэгчээр авах боломжтой гэж тооцоолсон гэсэн. Зураг төсвийн тусгай зөвшөөрөл зургийн компаниаар байгаа, үндсэн гүйцэтгэгч компанид байхгүй, тэхээр туслан гүйцэтгэгчийн хийж байгаа ажил нь өөрөө тусгай зөвшөөрөл хамаарах бол туслан гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг нийт шаардсан тусгай зөвшөөрлийн шаардлагад оруулж тооцох уу?

Хариулт: Зураг төсвийн тусгай зөвшөөрлийг үнэлгээндээ харгалзаж үзэхгүй, ажил хийхэд шаардана. Үнэлгээнд барилга угсралтын тусгай зөвшөөрлийг шаардсан байгаа.

Асуулт: Түүнтэй адилхан нэг тусгай зөвшөөрөл нь цахилгааны тусгай зөвшөөрөл байсан. Тэр нь ихэвчлэн барилга угсралтын компанид байхаасаа илүү цахилгааны ажлыг тусад нь хийдэг компаниудад байдаг. Энэ асуулт зөвхөн зураг төсөв биш, ямар нэгэн туслан гүйцэтгэгчийн хийх

гэж байгаа ажил маань туслан гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг энэ тусгай зөвшөөрөлд харгалзаж үзэх үү?

Хариулт: Зураг төсвөөс бусдыг харгалзаж үзнэ. Үндсэн компанид байхгүй үед туслан гүйцэтгэгчээр энэ цахилгааны ажлыг хийх юм байна гэж үзнэ.

Асуулт: Дараагийн 4 дэх асуулт ТШЗ 17.6.2 боловсон хүчний шаардлага байгаа. За тэнд заавал байх 6 хүний нэгэнд нь Автозамын инженер байна гэсэн байгаа, мөн тухайн компанийн үндсэн ажилтан байна гэсэн байгаа. Гэтэл барилга угсралтын компанид үндсэн ажилтнаар ажилдаг автозамын инженер цөөхөн бараг байхгүй гэж хэлж болно. Шаардлагатай үед хөлсөөр ажиллуулах гэрээгээр ажиллуулдаг. Энэ заалт өрсөлдөөнийг хязгаарласан шаардлага гэж харж байна. Барилга угсралтын компаниудын хувьд энэ хүнийг уян хатан байдлаар зохицуулах боломжтой юу?

Хариулт: Автозамын инженерийн хувьд та хэдийн бодож байгаа шиг бодож болно, гэхдээ бидний ажлын цар хүрээ маань ихэвчлэн зам дээр хийгдэж байгаа учраас талбайн тэгшилгээ, замын 2 үе шатны ажил хийгдэх болчоод байгаа. Нягтаршуулах гэх мэт. Замын инженерийн хувьд зайлшгүй байх шаардлагатай, гол нь үндсэн ажилтан байх эсэхийг Үнэлгээний хороон дээр ярилцаад хариу өгье.

Асуулт: За ойлголоо, дараагийн асуулт нь зураг төсвийн талбайн дэвсгэр зураг инженер геологийн дүгнэлт хийгдсэн үү?

Хариулт: Байхгүй ээ, хоосон талбай л байгаа.

Асуулт: Дэвсгэр зураг инженер геологийг өөрсдөө хийнэ гэж ойлголоо зөв үү?

Хариулт: Зөв.

Асуулт: За дараагийн асуулт техникийн нөхцлүүд зөвшилцөх гэсэн байгаа, захиалагчаас техникийн нөхцлийг хангаж өгөх ёстой. Техникийн нөхцөл гэхээр цахилгааны техникийн нөхцөл, ус, цэвэр бохир ус, дулаан, холбоо дохиолол гэх мэт тэр нь яаж явах юм бол?

Хариулт: Ус дулааны хувьд дулаан бол байхгүй, ус бол худгийн асуудлаар эсвэл зөөврийн асуудлаар шийдвэрлэн үүнийг зөвшилцөн гэж байгаа. Мэдээлэл холбоо дохиололыг холбогдох байгууллагаас бид зөвшөөрөл хүснэ. Тэрнийг бид аль болох ойрхон байхаар аль аль талдаа ашигтай байдлаар зөвшилцөж байж хүсэлтээ явуулна. Тийм учраас зөвшилцөх гэж оруулж өгсөн байгаа.

Асуулт: Аан за яагаад асуугаад байна гэхээр цахилгаан хангамжийн шаардлагууд байгаа 3,5 км орчим агаарын шугам гэх мэт эдгээр нь техникийн нөхцөлөөс хамаарах учраас асуусан юм.

Хариулт: Тийн тийн, өмнө нь төсвийн асуудал асуусан. Техникийн нөхцөлөөс хамаарч зурганд өөрчлөлт орох асуудал үүсч болзошгүй. Түүнийг хуулийн хүрээнд шийдэх боломжтой л гэж хэлсэн байгаа.

Асуулт: Ойлголоо, сүүлийн асуулт гадна дотно камер холбоо дохиололын зүйлүүд ороогүй байсан. Энэ тусдаа хийгдэх юм байна гэж ойлгосон зөв үү?

Хариулт: ТББ-т орсон байгаа. Дэвсгэр зурагт камер байрлах цэгүүдийг оруулж өгсөн байгаа.

Асуулт: Ойлголоо, дахиад сайн харья. Скизийг танайхаас өгөгдсөн дэвсгэр зураг ерөнхий төлөвлөгөөнд үндэслэж хийх үү?

Хариулт: Тэгнэ, бид нартай зөвшилцөх зүйл гарах байх. Бид аль болох төсөвтөө багтааж зөвшилцөнө.

Асуулт: Ойлголоо, манай асуулт болсон. Салхины хаалт гээд 12 м өндөр хаалтын хувьд Хурдын Нарны хороололд байдаг шиг гэж үзэж байгаа юу?

Хариулт: Үгүй, манай нүүрсний агуулахын 12м өндөр хана байдаг, тэр ханаар тооцсон.

Үнэлгээний хорооны гишүүн: Өөр тодруулах зүйл байхгүй бол уулзалтаа өндөрлөө. өнөөдрийн уулзалтад оролцсонд та бүхэнд баярлалаа. Амжилт хүсье.